



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** БУА-2025/139/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2025 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 7034-2580  
Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид  
Утас: 9511-2689 Цахим хаяг: [tsesb.audit@gmail.com](mailto:tsesb.audit@gmail.com)

Ахлах аудитор Ш.Ганчимэг Утас: 9937-7360  
Цахим хаяг: [shagdarganchimeg44@gmail.com](mailto:shagdarganchimeg44@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.29

№

174

танай

ны №

т

БУЛГАН СУМЫН ЕБС-ИЙН 2 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Б.ОЮУНСУВД ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Булган сумын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ЕБС-ийн 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам" хэрэгжиж эхэлсэн байна. Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/415 дугаар тушаалаар санхүүжилтийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулснаар 12 дугаар сарын 28-ны өдөр 108.7 сая төгрөгийн санхүүжилт орж ирсэн нь тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн данс 139.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарахад нөлөөлсөн байна.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд дээрх тогтоолын 7.7.2-т заасныг үндэслэн сургалтын тоног төхөөрмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж "Спийт Аксон" ХХК-тай 5 жилийн хугацаатай гэрээ байгуулан авснаар 57.1 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

632502290

### **Бусад асуудлын хэсэг**

Булган сумын ЕБС-ийн 2 сургууль 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ төлөвлөж, биелэлтийг 85.2 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>283,441,440</b>	<b>328,187,791</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>140,490,369</b>	<b>139,363,751</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>140,490,369</b>	<b>139,363,751</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	140,490,369	139,363,751
31211	Төрийн сангийн харилцах	140,490,369	139,363,751
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	200,865
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	200,865
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>142,951,071</b>	<b>188,623,174</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>41,540,041</b>	<b>428,260</b>
35110	Тусгай зориулалттай материал	41,084,575	-
35130	Эм боох материал	455,466	428,260
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11,180,186	11,180,186
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>86,110,843</b>	<b>173,034,728</b>
35410	Бичиг хэргийн материал	2,039,650	408,000
35420	Аж ахуйн материал	65,297,870	1,618,300
35430	Сэлбэг хэрэгсэл	6,287,774	6,287,774
35440	Түлш, шатах тослох материал	-	-
35450	Барилгын засварын материал	6,093,884	1,539,750
35460	Хүнсний материал	4,013,050	15,382,780
35470	Бусад хангамжийн материал	2,378,615	147,798,124
35500	Биологийн хөрөнгө	-	-
35600	Мал амьтад	4,120,000	3,980,000
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,995,705,931</b>	<b>2,205,346,218</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,995,705,931</b>	<b>2,205,346,218</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,675,302,231</b>	<b>1,863,438,874</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,748,054,887	1,763,054,887
39202	Хуримтлагдсан элэгдэл	(608,984,410)	(734,551,318)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	534,479,089	900,498,911
39206	Хуримтлагдсан элэгдэл	(190,523,114)	(309,444,217)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	181,996,103	262,053,008
39208	Хуримтлагдсан элэгдэл	(95,879,669)	(127,229,499)
39214	Бусад үндсэн хөрөнгө	171,301,002	179,961,002
39215	Хуримтлагдсан элэгдэл	(85,913,518)	(91,910,761)
39217	Ном	20,771,861	21,006,861
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>320,403,700</b>	<b>341,907,344</b>
39301	Програм хангамж	5,218,000	28,424,333
39302	Хуримтлагдсан элэгдэл	(630,300)	(2,332,989)
39303	Бусад биет бус хөрөнгө	315,816,000	315,816,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,279,147,371</b>	<b>2,533,534,009</b>

4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,233,300</b>	<b>95,838,927</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,233,300</b>	<b>95,838,927</b>
413	<b>Өглөг</b>	<b>3,233,300</b>	<b>95,838,927</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	19,895,183
4136	<b>Бусад өглөг</b>	<b>2,231,500</b>	<b>75,943,745</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	2,231,500	75,943,745
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,275,914,071</b>	<b>2,437,695,082</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,275,914,071</b>	<b>2,437,695,082</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,850,088,185	1,850,088,185
51101	Өмч: - төрийн	1,850,088,185	1,850,088,185
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(4,134,260,244)</b>	<b>(3,972,479,233)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(4,336,605,737)	(4,336,605,737)
51220	Тайлант үеийн үр дүн	202,345,493	364,126,504
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,560,086,130	4,560,086,130
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,279,147,371</b>	<b>2,533,534,009</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,837,077,267.90</b>	<b>4,487,585,439.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>249,505,967.90</b>	<b>263,480,439.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>249,505,967.90</b>	<b>263,480,439.00</b>
120001	Хувьцааны ногдол ашиг	00.00	550,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	<b>249,505,967.90</b>	<b>00.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,098,900.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,678,450.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	237,728,617.90	00.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,587,571,300.00</b>	<b>4,224,105,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,095,657,700.00</b>	<b>3,686,891,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,095,657,700.00	3,686,891,400.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,000,000.00</b>	<b>50,000,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00	50,000,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>484,913,600.00</b>	<b>487,213,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	484,913,600.00	487,213,600.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,616,189,614.74</b>	<b>4,325,664,427.79</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,616,189,614.74</b>	<b>4,325,664,427.79</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,448,155,095.94</b>	<b>4,147,864,446.56</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,349,864,765.87</b>	<b>2,850,519,282.58</b>
210101	Үндсэн цалин	1,407,987,939.07	1,765,862,408.93
210102	Нэмэгдэл	834,502,630.35	893,274,848.31
210104	Урамшуулал	107,374,196.45	191,382,025.34
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>294,246,318.75</b>	<b>353,627,134.57</b>

210201	Тэтгэврийн даатгал	200,098,765.77	240,402,234.57
210202	Тэтгэмжийн даатгал	23,430,213.41	28,306,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,876,273.12	14,153,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,767,082.76	14,153,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	47,073,983.69	56,612,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>452,007,731.20</b>	<b>452,544,573.77</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,598,586.58	20,308,840.62
210302	Түлш, халаалт	403,140,697.70	403,113,600.00
210303	Цэвэр, бохир ус	31,268,446.92	29,122,133.15
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,788,216.47</b>	<b>6,723,700.00</b>
210401	Бичиг хэрэг	00.00	3,520,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	3,202,800.00
210408	Бараа материал акталсны зардал	20,788,216.47	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>698,984.40</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	698,984.40
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,650,580.00</b>	<b>69,562,409.00</b>
210604	Урсгал засвар	32,650,580.00	69,562,409.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,694,193.66</b>	<b>40,002,608.17</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,554,400.00	18,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,139,793.66	39,983,708.17
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>275,903,289.99</b>	<b>374,185,754.07</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,547,205.00	76,654,081.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,609,600.00	13,993,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	206,746,484.99	283,537,773.07
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>168,034,518.80</b>	<b>177,799,981.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>167,119,730.00</b>	<b>177,609,050.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	167,119,730.00	177,609,050.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>914,788.80</b>	<b>190,931.23</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>220,887,653.16</b>	<b>161,921,011.21</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,870,000.00</b>	<b>1,335,000.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,870,000.00	00.00
145003	Хөрөнгө оруулалтын олз	00.00	1,335,000.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,412,160.26</b>	<b>1,475,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,286,900.26	00.00
225003	Хөрөнгө оруулалтын гарз	00.00	1,475,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	7,125,260.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(18,542,160)</b>	<b>(140,000)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>202,345,492.90</b>	<b>161,781,011.21</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,599,348,650.00</b>	<b>4,229,161,400.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,777,350.00</b>	<b>5,056,400.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	11,777,350.00	5,056,400.00
120001	Хувьцааны ногдол ашиг	-	5,056,400.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	11,777,350.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,098,900.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,678,450.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,587,571,300.00</b>	<b>4,224,105,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,095,657,700.00	3,686,891,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,095,657,700.00	3,686,891,400.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,000,000.00	50,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00	50,000,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	484,913,600.00	487,213,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	484,913,600.00	487,213,600.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,401,718,689.68</b>	<b>4,072,424,141.17</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,401,718,689.68</b>	<b>4,072,424,141.17</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,229,741,120.88</b>	<b>3,883,314,429.94</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,349,864,765.87	2,830,624,100.00
210101	Үндсэн цалин	1,407,987,939.07	1,751,843,421.69
210102	Нэмэгдэл	834,502,630.35	893,274,848.31
210104	Урамшуулал	107,374,196.45	185,505,830.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	294,246,318.75	353,828,000.00
210201	Тэтгэврийн даатгал	200,098,765.77	240,603,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	23,430,213.41	28,306,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,876,273.12	14,153,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,767,082.76	14,153,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	47,073,983.69	56,612,500.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	452,007,731.20	452,544,573.77
210301	Гэрэл, цахилгаан	17,598,586.58	20,308,840.62
210302	Түлш, халаалт	403,140,697.70	403,113,600.00
210303	Цэвэр, бохир ус	31,268,446.92	29,122,133.15
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	31,991,080.00	13,229,095.00
210604	Урсгал засвар	31,991,080.00	13,229,095.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	23,266,393.66	47,352,308.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,554,400.00	4,525,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,711,993.66	42,827,008.17
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	78,364,831.40	185,736,353.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,477,731.40	155,874,253.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,887,100.00	29,862,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>171,977,568.80</b>	<b>189,109,711.23</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	171,062,780.00	188,918,780.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	171,062,780.00	188,918,780.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	914,788.80	190,931.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>197,629,960.32</u>	<u>156,737,258.83</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	70,622,200.00	157,863,876.28
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,622,200.00	157,863,876.28
2200	Дотоод эх үүсвэрээр	70,622,200.00	157,863,876.28
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	70,622,200.00	157,863,876.28
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(70,622,200.00)</u>	<u>(157,863,876.28)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	127,007,760.32	(1,126,617.45)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,482,608.42	140,490,368.74
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	140,490,368.74	139,363,751.29

#### 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	(4,657,781,359.03)	1,754,075,702.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,850,088,184.62	4,561,768,877.33	(4,657,781,359.03)	1,754,075,702.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	464,789,917.11	464,789,917.11
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,560,086,130.33	(4,134,260,244.28)	2,275,914,070.67
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,560,086,130.33	(4,134,260,244.28)	2,275,914,070.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,850,088,184.62	4,560,086,130.33	(4,134,260,244.28)	2,275,914,070.67
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	161,781,011.21	161,781,011.21
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,850,088,184.62	4,560,086,130.33	(3,972,479,233.07)	2,437,695,081.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,419,269,900.00</b>	<b>4,230,097,086.22</b>	<b>189,172,814</b>	<b>95.72</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,419,269,900.00</b>	<b>4,230,097,086.22</b>	<b>189,172,814</b>	<b>95.72</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,230,351,100.00</b>	<b>4,041,178,306.22</b>	<b>189,172,794</b>	<b>95.53</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,924,269,200.00</b>	<b>2,830,624,100.00</b>	<b>93,645,100</b>	<b>96.80</b>
210101	Үндсэн цалин	1,973,451,400.00	1,751,843,421.69	221,607,978	88.77
210102	Нэмэгдэл	816,655,100.00	893,274,848.31	(76,619,748)	109.38
210104	Урамшуулал	134,162,700.00	185,505,830.00	(51,343,130)	138.27
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>365,533,500.00</b>	<b>353,828,000.00</b>	<b>11,705,500</b>	<b>96.80</b>
210201	Тэтгэврийн даатгал	248,562,900.00	240,603,100.00	7,959,800	96.80
210202	Тэтгэмжийн даатгал	29,242,600.00	28,306,200.00	936,400	96.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,621,300.00	14,153,100.00	468,200	96.80
210204	Ажилгүйдлийн даатгал	14,621,300.00	14,153,100.00	468,200	96.80
210205	Эрүүл мэндийн даатгал	58,485,400.00	56,612,500.00	1,872,900	96.80
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>452,713,600.00</b>	<b>452,544,573.77</b>	<b>169,026</b>	<b>99.96</b>
210301	Гэрэл, цахилгаан	20,200,000.00	20,308,840.62	(108,841)	100.54
210302	Түлш, халаалт	403,113,600.00	403,113,600.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	29,400,000.00	29,122,133.15	277,867	99.05
210604	Урсгал засвар	34,500,000.00	34,478,095.00	21,905	99.94
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>80,787,700.00</b>	<b>62,695,913.45</b>	<b>18,091,787</b>	<b>77.61</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,525,300.00	4,525,300.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	76,262,400.00	58,170,613.45	18,091,787	76.28
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>322547100.00</b>	<b>307007624.00</b>	<b>15,539,476</b>	<b>95.18</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	292,685,000.00	277,145,524.00	15,539,476	94.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,862,100.00	29,862,100.00	-	100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>188918800.00</b>	<b>188918780.00</b>	<b>20</b>	<b>100.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>188,918,800.00</b>	<b>188,918,780.00</b>	<b>20</b>	<b>100.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	188,918,800.00	188,918,780.00	20	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,261,878,000.00</b>	<b>4,229,161,400.00</b>	<b>32,716,600</b>	<b>99.23</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,669,391,800.00</b>	<b>3,686,891,400.00</b>	<b>(17,499,600)</b>	<b>100.48</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,669,391,800.00	3,686,891,400.00	(17,499,600)	100.48
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	50,000,000.00	50,000,000.00	-	100.00

132001	Орон нутгийн төсвөөс	487,213,600.00	487,213,600.00	-	100.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>5,272,600.00</b>	<b>5,056,400.00</b>	<b>216,200</b>	<b>95.90</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	550,000.00	550,000.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,506,400.00	4,506,400.00	-	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	766,200.00	00.00	766,200	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>140,490,368.74</b>	<b>(140,490,369)</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>139,363,751.29</b>	<b>(139,363,751)</b>	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад санхүүгийн тайланд 76,229.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, бүтэц орон тоонд батлагдаагүй ажил үүргийг хавсруулсан, илүү цагийн хөлсийг илүү тооцсон, тушаал шийдвэргүйгээр олгосон зөрчилд 2,044.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, нягтлан бодох бүртгэл, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой зөрчилд 2 зөвлөмж өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Сургуулийн захиралд тушаал шийдвэргүйгээр 718.0 мянга, нягтлан бодогч, нярав нарт тухайн сарын ажиллавал зохих цагийн 10 хувиас хэтрүүлэн 822.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс нийт 1,540.0 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 4.1, заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

2. Сургуулийн бүтэц орон тоонд батлагдаагүй технологийн мэргэжилтэн албан тушаалд томилж, хавсран ажилласны нэмэгдэл хөлсөнд 504.5 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн.” гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоов.

#### 3.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 3.3 Зөвлөмж

#### 5.3.1 Илрүүлэлт:

Сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглах хугацаа дууссан элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгүүдийг ажилтнуудад картаар эзэмшүүлэн ашиглаж байгаа нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

#### Өгсөн зөвлөмж:

Ашиглагдах хугацаа дууссан, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгүүдийг сургуулийн Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж, холбогдох хууль журмын дагуу дахин үнэлгээ хийж, бүртгэлд тусгах.

#### 5.3.2 Илрүүлэлт:

Тайлант оны цалин хөлс, өглөг, авлагатай холбоотой журнал, дансны бичилт нь УСНББОУС, НББ-ийн зарчимтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

#### Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1, 14 дүгээр зүйлийн 14.3, Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллах.

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй хөрөнгийн орлогыг бүртгэлд илүү тусгасан.	1	5,670.0			1	5,670.0	1	5,670.0				
Үр дүнгийн тайланд цалингийн зардал дутуу тусгасан.	1	9,945.2			1	9,945.2	1	9,945.2				
Үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодуулсан.	1	30,617.4	1	30,617.4			1	30,617.4				





